



Оюутны бие даалтын ажилд зөвлөн туслах механизм ("Хүүхдийн хэл ярианы хөгжил" хичээлийн жишээн дээр)

Ц.Наранцэцэг

Хөлөнбуйр Их Сургууль

Холбоо барих зохиогч: ts_narantsetseg@msue.edu.mn

Хүлээн авсан: 2020.04.02

Хянагдсан: 2020.09.14

Зөвшөөрсөн: 2020.09.28

Хураангуй

Өнөө үед боловсролын шинэчлэлийн асуудлын хүрээнд олон ажил хийгдэж байна. Үүний нэг бол хөтөлбөрийн шинэчлэл юм. Багшийн үйл ажиллагааны мөн чанар нь оюутнуудын сурах үйлдээ хандах хандлагыг төлөвшүүлж, зорилго, зорилтоо ухамсартай тодорхойлж, хэрэгжүүлэх арга технологио боловсруулан, хэрэглэх зүйлээ оновчтой сонгоход тусалж, алдааг цаг алдалгүй засаж, үнэлж сайжруулахад оршино.

Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн "Хүүхдийн хэл ярианы хөгжил" хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд оюутны бие даалтын ажлын гүйцэтгэл, чанарыг сайжруулахын тулд 2016 оноос оюутанд зөвлөн туслах механизмыг туршсан (Thanh, 2015). Оюутанд бие даалтын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь системтэй бус байгаад бид дүгнэлт хийж, бие даалтын зөвлөгөө өгөх механизмыг нарийвчлан боловсруулсан юм. Оюутны бие даалтын ажилд зөвлөн туслах үйл ажиллагаа нь ерөнхий зөвлөгөө, улирлын болон төгсөлтийн шалгалтад зориулсан, нарийвчилсан, багшаас бусад хэлбэрийн зөвлөгөө гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Эдгээр хэсэг тус бүр 3-8 чиглэлтэй. 2016 оноос туршсан туршилтын ажлын үр дүнг тодорхойлохын тулд сүүлийн 3 жилийн суралцагчдын бие даалтын ажлаас тус бүр 30 оюутны ажлыг түүвэрлэн чанарын анализ хийж үзлээ. Оюутны бие даалтын ажлыг онолын үндэслэлээ тодорхойлсон байдал, хэрэглэгдэхүүний сонголт, ажлаа баримтжуулсан байдал, дүгнэлтээ оновчтой тодорхойлсон байдал, бичлэгийн стандарт гэсэн 5 үндсэн шалгуурын дагуу рубрик үнэлгээгээр үнэлсэн. Оюутны бие даалтын ажлын чанар багшийн системтэй зөвлөгөө өгөхөөс шууд шалтгаалж байгаа нь бидний сүүлийн 3 жилийн ажлын харьцуулалт, үр дүнгээс харагдлаа. Бид энэхүү өгүүлэлдээ сургуулийн өмнөх боловсролын сургуулийн "Хүүхдийн хэл ярианы хөгжил" хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хийсэн оюутны бие даалтын ажлын гүйцэтгэл, чанарт хийсэн дүн шинжилгээг танилцуулж байна.

Түлхүүр үг

Хичээлийн хөтөлбөр, хүүхдийн хэл ярианы хөгжил, оюутны бие даалтын ажил



Удиртгал

Багш зааж байгаа хичээлээ оюутан бүрд хүртээмжтэй, ойлгомжтой байлгахын тулд сургалтын арга зүйгээ тасралтгүй сайжруулан эрэлт хайгуул хийж, судалгаа туршилттай ажиллах шаардлагатай. Хичээлийн үр дүнг хөтөлбөрөөр хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө агуулгын хувьд мэдлэг нь практик хэрэглээтэй залгамж холбоотой байх, арга зүйн хувьд үр дүнд суурилсан сургалтын арга, технологи, зохион байгуулалтыг ашигласан байх, үнэлгээний хувьд оюутны хөгжил, төлөвшил, ахиц дэвшлийг хэмжих, чанарыг үнэлдэг байх, өөрийн үнэлгээ хэрэглэдэг байх гэсэн үндсэн шаардлагууд тавигдаж байна. Багшаас оюутанд тавьж байгаа үнэлгээ нь тухайн хичээлээр өгч байгаа мэдлэг чадвар, дадлыг оюутан хэр түвшинд эзэмшиж байгааг харуулахаас гадна оюутны хувьд ч гэсэн тухайн үнэлгээгээ хүлээн зөвшөөрдөг бодитой үнэлгээ байх ёстой.

Хичээлийн хөтөлбөр бол далайд хөвж яваа мөсөн уулын зөвхөн ил байгаа хэсэг гэж ойлгож болох бөгөөд өнөө үед хөтөлбөрийн судлагдахууны талаарх мэдлэг, ойлголт, чадварыг ил харагдах хэсгээр нь загварчлан авч үзэх нийтлэг хандлага байна.

“Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээлийн хөтөлбөр тодорхой үр дүнд хүрч хөгжиж ирсэн боловч өнөөдөр бидний чухалчлан ярьж байгаа үр дүнд суурилсан хөтөлбөр мөн үү гэдгийг эргэн харж дүгнэвэл бодох, засварлах, шинэчлэх зүйл багагүй байна. Тухайн сургалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан хөтөлбөр болж чадсан эсэхийг хэмжих чухал хэрэгслийн нэг бол оюутны бие даалтын ажил ба түүний гүйцэтгэлийн чанар гэж үзэж болно. Оюутнууд хичээлийн явцад бүрэн эзэмшээгүй мэдлэг, чадвар, хандлагыг бие даалтын ажлыг хийж гүйцэтгэх явцдаа эзэмшихээр төлөвлөн зохион байгуулах нь чухал. Үүнд мэдлэгийг бүрэн гүйцэд өөрийн болгох, гүнзгийрүүлэх, авьяас чадавхаа нээн хөгжүүлэх, бие дааж сэтгэн бодох, үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, хянан жолоодох, оновчтой шийдвэр гаргах, дүгнэлт хийх, зөрчилт байдлаас гарах, хариуцлагатай байх, багаар ажиллах, хамтрах, цаг барих зэрэг олон талын арга барил эзэмших явдал юм (Буянжаргал, А., Жаргалсайхан, Б., 2017).

Хичээлийн хөтөлбөр боловсруулах, шинэчлэх ажил юунаас эхлэх вэ? гэдэг асуултаас бидний үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд үүний тулд өнөөдөр тулгарч байгаа асуудлаа тодорхойлох, мэргэжлийн дидактикийн хөтөлбөрүүдийн нэгдэж интеграцлагдах талбарыг тодорхой болгох /бүтэц, бие даалтын ажил, суралцагчийн эзэмшвэл зохих чадвар, чадамж, хандлага гэх мэт) зэрэг асуудлууд бидний өмнөх тулгарсан.

2015 оноос хойш хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бид дараах чиглэлээр ажилласан. Үүнд:

- Өмнөх хөтөлбөрүүдэд анализ хийх
- Хөтөлбөрийн иж бүрдлийн логик холбоог сайжруулах
- Хөтөлбөрийн онол, арга зүйн үндсийг эргэн харж зарим шинэчлэлийг хийх

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нөөц хэрэглэгдэхүүний хөгжил, хүртээмжийг судлах
- Хичээлийн агуулгын хүрээнд оюутанд зориулсан веб сайт ажиллуулах
- Сэдвийн хүрээнд оюутанд зориулсан (reader`s book) унших материалыг бэлтгэх (pdf-ээр болон бусад)
- Оюутны бие даалтын ажлыг хэлбэр, агуулга, хэмжээгээр матриц гаргах
- Лекцийн шинэчлэлийг судалгаанд тулгуурлан боловсруулах
- Прогресс тестийн санг бүрдүүлэх (Блумын таксономын дагуу боловсруулалт хийх)
- Ном зүйг шинэчлэн, бүлэг сэдэв бүр дээр унших ном болон хуудсыг тодорхой заах
- Хөтөлбөрт чек листийн дагуу үнэлгээ хийх гэсэн зорилтын хүрээнд ажилласан болно.

Тухайн хичээлийн стандартыг хэрэгжүүлэх хичээлийн хөтөлбөр хэд хэдэн хувилбартай (багш бүр өөрийн онцлогтой хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг) байхыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, агуулгын хувьд судлагдахууны тогтолцоогоор, эсвэл чадвараар нь модульчилсан гэх мэт мөн арга зүйн хувьд багш бүр өөр аргазүй, технологиор боловсруулсан байж болно. “Хүүхдийн хэл ярианы хөгжил” хөтөлбөрийн хувьд:

- Хөтөлбөрийг судлагдахууны тогтолцоогоор модульчлан боловсруулсан.
- Хүний хөгжил, танин мэдэхүйн онол, хэлийг эзэмших тухай онолд тулгуурласан.
- Хүүхдийн хэл яриаг олон талтай, цогц хөгжүүлэх арга зүйд суурилсан (Сохин.Ф.А., 2002).
- Төсөлд суурилсан, агуулга нь идэвхтэй, сургалтын орчин шаардсан дизайнтай.
- Хөтөлбөрийг агуулга тал гэхээс илүүтэйгээр гүйцэтгэлийн чанарын үр дүнд чиглэсэн үйлийн бүтцээр нь боловсруулахыг чухалчилсан.
- Эцсийн үр дүнг чухалчлахаас илүү явцын үр дүнг эрхэмлэсэн.
- Сургалтын үйл ажиллагаанд суралцагч, багш хэн хэн нь идэвхтэй үүрэг оролцоотой байхаар боловсруулсан гэж үзэж байна.

Дээрх шинэчлэлийн хүрээнд хөтөлбөрийн үр дүнг хэмжих хамгийн чухал үзүүлэлт бол оюутны бие даалтын ажил гэдэг нь тодорхой юм.

Монголын эрдэмтэн Б.Батхуяг, С.Энхтүвшин нар “Оюутнуудын дийлэнх нь бие даан ажиллах арга барилд үндсэндээ суралцаж чадалгүй сургуулиа дүүргэж байна. Оюутнууд бие даалтын ажлыг дүн авахын тулд хэлбэрдэх төдий хийж байна. Тэд сурах үйл ажиллагаагаа төлөвлөх, зохион байгуулах чадвараар сул байна (Энхтүвшин, 2012). Оюутнуудад гарын авлага, зөвлөмж дутагдсанаас бага уншиж байна. Эдгээр шалтгаан нь эргээд бие даалтын ажлын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна” гэж дүгнэжээ (Батхуяг, 2006).

Оюутны бие даалтын ажил гэж нэг талаас сургалтын стандарт, хөтөлбөр нөгөөтээгүүр оюутны сонирхол, чадавх зэргийг харгалзсан хичээлийн болон хичээлийн бус цагаар багшийн шууд бус удирдлага дор явагддаг оюутны бие дааж суралцах бүтээлч үйл ажиллагаа. (Энхээ, Д., Мягмаржав, Б., & Вергелес, Г.И., 2016, х. 168-172)

Оюутны хөгжилд тэдний идэвхтэй бие даасан үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй. Мэдлэг нь дамждаг биш хүн өөртөө бий болгон бүтээдэг бүтэцлэг шинжтэй учраас оюуны схем, бүтцийн өөрчлөлт буюу шинэ бүтэц үүсэх хэлбэрээр явагдана гэж үздэг. (Алтангэрэл, 2020, х. 110)

Аливаа үйл ажиллагааны үр дүнд түүнийг гүйцэтгэгчид шинэ мэдлэг, чадвар төлөвших буюу эсвэл урьдах мэдлэг чадвар шинэ шинж чанарт олж байдаг байгаа юм. Мэдлэгийн чанар нь түүнийг эзэмшихийн тулд ашигласан үйл ажиллагааны шинж чанараар тодорхойлогдоно (Ф.А.Талызина, 1998) гэж үзсэнийг бид судалгааны ажлын онолын үндэслэл болгон бие даалтын ажилд зөвлөн туслах механизмыг боловсруулсан болно.

Судалгааны арга зүй

Оюутнуудын хийж гүйцэтгэсэн бие даалтын ажлын чанар, гүйцэтгэл багшийн оюутантай ажиллах, зөвлөх үйл ажиллагаа болох эргэх холбооноос ихээхэн шалтгаалдаг болохыг бидний судалгаа тодорхой харуулсан юм. Энэхүү судалгааны ажлыг 2016 оноос эхлэн туршиж хэрэгжүүлсэн. Судалгааны ажил дараах шатлалаар явагдсан. Үүнд:

- 2015 - 2016 онд оюутны бие даалтын ажлын гүйцэтгэл, чанарын байдлыг тогтоох
- Бие даалтын ажлын чанарыг сайжруулахын тулд оюутнуудад зөвлөн туслах механизмыг боловсруулах
- Оюутанд зөвлөн туслах механизмыг практикт турших
- Үр дүнг харьцуулж, дүн шинжилгээ хийх гэсэн чиглэлд ажиллалаа.

СӨБС-ийн сургалтын төлөвлөгөөнд “Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээл 3-р курсийн 1-р улиралд ордог бөгөөд тухайн улиралд орж байгаа хичээлүүдийн бие даалтыг ажлын хэлбэрийг матрицлан авч үзье (Хүснэгт 1).

Багш нар оюутны бие даалтын ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулахын тулд хамтран нэгдсэн удирдамж боловсруулж, хэрхэн үнэлгээ өгөх талаар сайтар ярилцаж төлөвлөх шаардлагатай болж байна. Энэ бол бидний цаашид хийх ажлын нэг юм. Оюутны бие даалтын ажлын чанарыг сайжруулахын тулд бие даалтын зөвлөгөө өгөх ажлыг тодорхой оновчтой болгох нь чухал. Ихэнх их сургуулийн багш нар олон оюутантай ажилладаг, оюутан бүрд хүрч олон дахин зөвлөн туслах нь төдийлөн боломжгүй зүйл гэж үздэг. Нэг улирлын туршид оюутан бүрд 5-аас доошгүй удаа зөвлөн туслах боломж байна уу? гэдэг асуулт урган гарч ирж байна.

Хүснэгт 1 СӨБС-ийн 3-р курсийн намрын улирлын хичээлийн бие даалтын матриц
3А (намар): V

Заавал судлах		16	Бие даалтын ажлын хэлбэр	Нэгдмэл байдлаар бие даалт өгөх боломжтой хичээлүүд	Боломжит хувилбар
T.PD301	Хүүхдийн бие бялдрын хөгжил	2	Судалгаа Зохномж	боломжтой	Төсөлт ажил
T.LD302	Хүүхдийн хэл ярианы хөгжил	2	Судалгаа Төсөлт ажил	боломжтой	
T.MD303	Хүүхдийн математик төсөөллийн хөгжил	2	Илтгэл Арга зүйн боловсруулалт	боломжтой	
T.SM402	Байгаль, орчинтой танилцах арга зүй	3	Тэмдэглэл Туршилт	боломжтой	
T.AM424	Дүрслэн урлахуйг хөгжүүлэх арга зүй	3	Хэрэглэгдэхүйн бэлтгэх Үйл ажиллагааны төлөвлөлт	боломжтой	
T.CH409	Найрал дуу	1	Тайлан тоглолт	боломжгүй	
T.TP260	Дагалдан суралцах дадлага	3		боломжтой	Төсөлт ажлаа гурших

“Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээлийг дунджаар жил бүр 300 орчим оюутан судалдаг бөгөөд нэг оюутанд 5 удаа, нийт оюутанд 1500 зөвлөгөөг багш өгөх шаардлагатай болно. Энэ нь бодит байдал дээр хэрэгжихэд хүндрэлтэй. Тиймээс бид оюутнуудын бие даалтын ажилд зөвлөн туслах ажлыг ерөнхий зөвлөгөө, улирлын болон төгсөлтийн шалгалтад зориулсан, нарийвчилсан, багшаас бусад хэлбэрийн зөвлөгөө гэсэн 4 том бүлэгт багцлан зөвлөн туслах олон хувилбарыг турших туршилтыг зохион байгуулсан. Оюутны тоо хэмжээнээс шалтгаалан анги нийтийг хамарсан, баг болон хэсэгчилсэн байдлаар, ганцаарчилсан, электрон хэлбэрийн гэсэн зөвлөгөөг системтэй төлөвлөсөн ба улирлын сүүлийн 7 хоногт бие даалтын ажлыг цаасан хэлбэрээр бэлтгэж, хамгийн эцсийн зөвлөгөөг авахаар зохион байгуулсан. Оюутнууд зөвлөгөө бүрийг өөрсдөө баримтжуулж улирлын эцэст бие даалтын ажилдаа өөрийн үнэлгээг өгч юунд суралцсан, ямар ахиц

дэвшил гарсан гэдгийг эргэцүүлснээр чанарын ахиц гарна гэж үзлээ. Оюутан нэг улиралд хамгийн цөөндөө 4 удаа зөвлөгөө авч баримтжуулсан байх шаардлага гарч ирнэ (хүснэгт 2).

Оюутанд бие даалтын ажлаа гүйцэтгэхэд дараах чиглэлээр зөвлөн туслахаар эргэх холбоог нарийвчлан төлөвлөсөн болно (Keane, E., Labhrainn, I. M., 2005)

Хүснэгт 2 Оюутны бие даалтын ажилд зөвлөгөө өгөх механизм (Feedback mechanisms)

	ЗӨВЛӨГӨӨ АВАХ ХЭЛБЭР, ЧИГЛЭЛ (Types of Feedback)	Тухайн төрлийн зөвлөгөө авсан тохиолдолд дараах тэмдэглэгээг хийнэ.
	Ерөнхий зөвлөгөө	
1	Аман зөвлөгөө (тухайн улиралд хийх бие даалтын ажлын удирдамжийг нийт оюутнуудад танилцуулах, төсөлт ажил болон арга зүйн боловсруулалтын сэдвээ сонгох чиглэлийг өгөх)	★
2	Бие даалтын ажлын сэдвийг тодорхой сонгон удирдамжтай танилцсаны эцэст ангид нэмэлт зөвлөгөө өгөх (оюутнуудад гарч ирсэн асуултад хариулт өгөх)	★
3	Багаар ажиллаж байгаа оюутнуудад зөвлөгөө өгөх (хуваарилагдсан баг тус бүрд)	*
4	Оюутанд ганцаарчилсан зөвлөгөө өгөх	*
5	Электрон хэлбэрээр зөвлөгөө өгөх (email- ээр хариу өгөх)	+
6	Веб сайтаар зөвлөгөө өгөх (childlangmgl.weebly.com)	+
7	Хэвлэж ирсэн бие даалтын ажилд зөвлөгөө өгөх	◇
8	Бусад	◇
	Улирлын болон төгсөлтийн шалгалтад зориулсан зөвлөгөө	
1	Явцын тест (энэ нь дүн өгөхдөө гол биш, оюутан ямар түвшинд явж байгааг мэдээлэх зорилготой)	*
2	Улирлын эцсийн шалгалтад зориулсан зөвлөгөө (ямар сэдвийн хүрээнд ямар хэлбэрийн шалгалт авах вэ, яаж үнэлэх вэ гэдгийг оюутнуудад урьдчилан зөвлөх)	★
3	Тойм лекц (тухайн хичээлээр үзсэн бүх сэдвийн хүрээнд оюутанд дутуу ойлгосон сэдэв чиглэлд зөвлөгөө өгөх)	★
4	Өнгөрсөн жилийн оюутнуудын төгсөлтийн шалгалт дээр гарсан давуу сул, алдаа оноотой талыг жишээ загвар үзүүлэн зөвлөх (төсөлт ажил, арга зүйн боловсруулалт)	★
5	Өнгөрсөн жилийн оюутнуудын бие даалтын ажлын шилдэг загваруудыг веб сайтад байрлуулан зөвлөгөө өгөх	+
	Нарийвчилсан зөвлөгөө	
1	Сэдвийн хүрээнд онолын үндэслэлийг тодорхойлсон байдалд зөвлөгөө өгөх	*
2	Хүүхдийн хэл ярианы хөгжлийн судалгаа хийхэд зөвлөгөө өгөх	*
3	Судалгааны үр дүнг нэгтгэсэн байдалд зөвлөгөө өгөх	*
4	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад зөвлөгөө өгөх	*
5	Үйл ажиллагааг зохион байгуулах, туршихад зөвлөгөө өгөх	*

6	Төсөлт ажлыг эмхлэн цэгцэлж, бичвэрийг боловсруулахад зөвлөгөө өгөх	◇
	Багшаас бусад хэлбэрийн зөвлөгөө	
1	Хамт суралцаж байгаа бусад оюутнуудаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх (энэ нь үнэлгээ хийхдээ гол биш бусдаас зөвлөгөө авахад оршино)	✓
2	Дадлага хийж байгаа цэцэрлэгийн багш, эрхлэгч, арга зүйчээс зөвлөгөө авах	✓
3	Өөрийн үнэлгээ хийж, эргэцүүлэмж бичих	✓

Зөвлөгөөний хэлбэрүүд, тэмдэглэгээний тайлбар

- ★ Анги нийтийг хамарсан зөвлөгөө
- * Баг, ганцаарчилсан зөвлөгөө
- + Интернэт, электрон хэлбэрийн зөвлөгөө
- ◇ Цаасаар хэвлэж бэлэн болсон даалгаварт өгөх зөвлөгөө
- ✓ Багшаас бусад хөндлөнгийн болон өөрийн үнэлгээ

“Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээлээр оюутнууд хэл ярианы хөгжлийн судалгааг 2-6 хүртэл насны хүүхдийн дунд зохион байгуулдаг бөгөөд бид бие даалтын ажлыг дараах шалгуурт үндэслэн үнэлдэг болно.

Хүснэгт 3 Бие даалтын ажлын үнэлгээний рубрик

Үнэлгээ						
	Шалгуур	Хангалтгүй (5-аас доош)	Дунджаас доогуур (6-10)	Дунд зэрэг (11-16)	Сайн (17-21)	Маш сайн (22-25)
1	Онолын үндэслэл тодорхойл-сон байдал	Онолын үндэслэл, мэдээлэл тодорхойлоогүй	Онолын үндэслэлийг оновчгүй тодорхойлсон	Онолын үндэслэлийг тодорхойлсон, сурах бичгээ ашигласан	Онолын үндэслэлийг зөв тодорхойлсон, мэргэжлийн ном, сурах бичиг ашигласан	Онолын үндэслэлийг оновчтой тодорхойлсон, мэдээллийн олон талт эх сурвалжийг бүтээлчээр эрэл хайгуул хийж харьцуулан судалсан
2	Хэрэглэгдэхүүн сонголт	Хэрэглэгдэхүүн бэлтгээгүй	Хэрэглэгдэхүүн оновчгүй, бүтээлч биш	Хэрэглэгдэхүүн оновчтой боловч бүтээлч байдал дутагдалтай	Хэрэглэгдэхүүн хүүхдэд ойлгогдохуйц, ойлгомжтой зурагтай, хэрэглэгдэхүүн материал чанарын шаардлага хангасан, бүтээлч байх	Хэрэглэгдэхүүн хүүхдэд ойлгогдохуйц, ойлгомжтой зурагтай, хэрэглэгдэхүүн материал чанарын шаардлага хангасан байх, бүтээлч, сонирхол татахуйц хийсэн, хэрэглэгдэхүүнээ оновчтой сонгосон
3	Баримтжуулалт	Фото зураг болон дүрс бичлэг	Фото зураг болон дүрс хийсэн боловч	Фото зураг болон дүрс хийсэн боловч	Фото зураг болон дүрс бичлэг хийсэн,	Фото зураг, дүрс бичлэгийг стандартын


		хийгээгүй	шаардлага хангаагүй	бага зэргийн алдаа гаргасан	судлаачийн ёс зүйг баримталсан	дагуу зөв хийсэн, судлаачийн ёс зүйг баримталсан, судлаачийн болон хүүхдийн байрлалыг зөв оновчтой сонгож авсан.
4	Дүгнэлт	Дүгнэлт бичээгүй	Судалгааны үр дүнг дүгнэх оролдлого хийсэн	Хүүхдийн хөгжлийг харьцуулан дүгнэсэн боловч дутуу	Хүүхдийн хөгжлийг онолын үндэслэлд тулгуурлан дүгнэсэн, шалгуур бүрийг харьцуулан дүгнэсэн	Хүүхдийн хөгжлийг онолын үндэслэлд тулгуурлан дүгнэсэн, шалгуур бүрийг харьцуулан оновчтой дүгнэсэн, цаашид дэвшүүлэх санаагаа тодорхойлсон
5	Бичлэгийн стандарт	Бичлэгийн зааврыг баримтлаагүй	Бичгийн соёлыг анхаарах тал дээр нэлээд алдаа гаргасан	Бичгийн соёлыг анхаарсан боловч зарим нэг алдаатай	Бичгийн соёлыг анхаарч өгөгдсөн зааврыг баримталсан, үг үсэг найрлагын алдаа 1-2 ыг гаргасан	Бичгийн соёлыг анхаарч өгөгдсөн зааврыг баримталсан, үг үсэг найрлагын алдаагүй, АРА форматын дагуу бичсэн байх

Судалгааны үр дүн

Оюутны бие даалтын ажлын үнэлгээний рубрик, шалгуурын дагуу (хүснэгт 3) сүүлийн 3 жилийн хугацааны 30 оюутны ажлыг түүвэрлэн дүгнэж үзэв. Үнэлгээний рубрикт заасан 5 шалгуурын дагуу 25 хүртэлх оноогоор 5 түвшинд үнэллээ.

Оюутны бие даалтын ажлын гүйцэтгэлээс харахад онолын үндэслэлийг тодорхойлох тал дээр бусад үзүүлэлтээс өндөр гарч байгаа нь энэ хичээл сурах бичиг болон гарын авлага материал хүрэлцээтэй болсонтой холбоотойгоос гадна 3-р курст орж ирсэн оюутнууд мэдээллийн эх сурвалжийг олж тогтоох, онол арга зүйн материалыг судалж, шүүрдэх чадвар ерөнхийдөө бүрэлдсэн байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Хэрэглэгдэхүүний сонголт гэсэн шалгуур бас өндөр үзүүлэлттэй гарч байгаа нь оюутнуудын жил бүрийн гүйцэтгэлээс харагдсан. Оюутнууд сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй, дүрслэн урлахуй зэрэг хичээлүүдээр олж авсан мэдлэг туршлагаа хүүхдийн хэл ярианы хөгжил хичээлээр ашиглаж чадаж байгааг харуулж байна.

График 1 Оюутны бие даалтын гүйцэтгэлийн чанар




2017 онд “Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээлийн бие даалтаар оюутнууд 25 оноо авах ёстойгоос дунджаар 14 оноо авсан бөгөөд гүйцэтгэл дунджаар 56% болж байна.

2018 оны оюутнуудын “Хүүхдийн хэл ярианы хөгжил” хичээлийн бие даалтын гүйцэтгэлээс харахад ерөнхийдөө ихэнх үзүүлэлт нийтлэг дунджаас доогуур гэж үнэлэгдсэн байна.

2018 оны оюутнуудын бие даалтын ажлын гүйцэтгэл дунд буюу сайн гэсэн үнэлгээ түлхүү авсан харагдаж байна. Энэ нь бие даалтын зөвлөгөө өгөх механизмыг оновчтой зохион байгуулж ажиллаж эхэлсэнтэй холбоотой. Бүх оюутнууд 4 -өөс дээш удаа зөвлөгөө авсан бөгөөд хамгийн их зөвлөгөө авсан оюутнууд дунджаар 16 удаа гэсэн тэмдэглэгээ хийгджээ. Энэ оны оюутнуудын бие даалтын ажлын гүйцэтгэл дунджаар 67% болж өссөн байна. 2019 оны оюутнуудын бие даалтын ажлын гүйцэтгэл нэлээд ахицтай гарч 79.5% гэсэн тоон дүн гарсан. Бие даалтын ажлын зөвлөгөө авсан тоо хэмжээ, гүйцэтгэлийн чанар хоёр шууд холбоотой байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байгаа юм.

Судалгааны тоон мэдээллийг гаргахдаа бие даалтын ажлын үнэлгээний рубрикийг (хүснэгт 3)-ыг ашиглан гаргасан бөгөөд оюутны бие даалтын ажлын явцад онолын үндэслэлийг тодорхойлсон байдал, хэрэглэгдэхүүний сонголт, баримтжуулалт, дүгнэлт, бичлэгийн стандарт гэсэн 5 шалгуурын дагуу 0-25 хүртэл оноогоор оноожуулан үнэлсэн болно.


График 2 Оюутны бие даалтын ажлын гүйцэтгэл



Оюутны бие даалтын ажлын гүйцэтгэл жил бүр сайжирч байгааг бид зөвлөгөө өгөх механизмтай холбон тайлбарлаж байна. Учир нь оюутнууд багштай тогтсон схемийн дагуу тодорхой цагт холбогдон байнга зөвлөгөө авч ажилласнаар хийж байгаа ажлынхаа мөн чанарыг ойлгох, асуудлаа оновчтой тодорхойлох, ажлын явцад гарч байгаа алдаа оноогоо дор бүрд нь хянаж цэгцлэх, засварлах гэх мэт олон эерэг үр дүн гарч байгаа нь бидний судалгаанаас харагдлаа (график 3).

Хамгийн сайн баг дунджаар 23 удаа зөвлөгөө авч ажилласан байна. Зөвлөн туслах ажлыг зөвхөн багш хийх боломжгүй. Энэ нь хэт ачаалалд хүрч цаг хугацааны хувьд учир дутагдалтай байдал үүснэ. Зөвлөгөөг нийтэд хандсан, ангид хандсан, баг, жижиг бүлэгт хандсан, оюутнууд харилцан бие биедээ хандсан гэх мэт олон хувилбартайгаар зохион байгуулж, оюутнууд аль болох бүтээлчээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллахаар зохион байгуулсан нь үр дүнд хүрч байна. Оюутнууд зөвлөгөөг хаанаас хэрхэн авч болохыг эрж хайж (эмэйлээр, дадлагын бааз цэцэрлэгийн багш нараас, багшийн веб сайтаас, мэргэжлийн веб хуудаснаас, өнгөрсөн жилийн оюутнуудын шилдэг бие даалтын ажлын туршлагаас гэх мэт) ажиллах бөгөөд зөвлөгөө бүрээ тэмдэглэн дүн шинжилгээ хийж, улирлын төгсгөлд хэдэн удаа хаанаас зөвлөгөө тусалцаа авч ажилласнаа танилцуулсан болно.

График 3 Оюутны бие даалтын гүйцэтгэлийн чанар ба зөвлөгөө авсан тоо



Бие даалтын ажилд зөвлөн туслах механизм нь оюутанд олон талаар хөгжих, ажлаа чанартай гүйцэтгэхэд нь нөлөөлөөд зогсохгүй, багш өөрийн зөвлөх үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, улмаар хичээлийн хөтөлбөр сайжрах түлхэц болох юм.

Дүгнэлт

- Сургалтын хөтөлбөр нь өмнө боловсруулсан хөтөлбөртөө анализ хийж, цаашид хөгжих учиртай. Сургалтын хөтөлбөрийг оюутны чадамжид суурилан, хамтын оролцооны зарчим болон хичээлийн болон хөтөлбөрийн судалгаанд тулгуурлан дахин сайжруулдаг байх (intended, implemented, learned curriculum) нь чухал.
- Оюутны бие даалтын ажлын чанар (Feedback mechanisms) зөвлөгөө өгөх механизмыг оновчтой боловсруулан хэрэгжүүлэхээс шууд шалтгаалж байна. Бие даалтын зөвлөгөөг хаанаас ямар арга замаар хэрхэн авч болохыг багш оюутнуудад улирлын эхэнд сайтар тайлбарлаж, зөвлөгөө өгөх төлөвлөгөөг системтэй нарийн боловсруулж ажилласнаар үр дүнд хүрнэ.
- Бие даалтын ажлыг ганц багш зөвлөж ажиллах нь ачааллыг хэт нэмэгдүүлэн оюутны идэвх, сонирхлыг бууруулах сөрөг талтай бөгөөд зөвлөн туслах олон талт хувилбарыг ашиглах боломжтой гэж үзлээ.
- Хүүхдийн хэл ярианы хөгжил хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх иж бүрдэл хэрэглэгдэхүүн (сурах бичиг, дасгал ажил гэх мэт)-ий логик холбоог анхаарч бие даалтын ажилтай холбон цаашид улам сайжруулан ажиллах шаардлагатай.
- Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх хичээлийн бие даалтын ажлыг цаашид бусад хичээлүүдийн бие даалтын ажилтай интеграцчилан матриц үүсгэн хэлбэр, агуулга, хэмжээ, ачаалал зэрэгт дүн шинжилгээ хийх, тухайн улиралд хичээл зааж байгаа багш нартайгаа хамтран төлөвлөх зэрэг нь оюутанд очих ачааллыг зохицуулах чухал алхам болох юм.
- Цаашид оюутны бие даалтын ажлын гүйцэтгэлийг улам сайжруулахын тулд багш үнэлгээний шалгуураа (хүснэгт 2 ба 3) алхамчлан зөвлөх үйл ажиллагаатайгаа нягт холбож, түүндээ дүн шинжилгээ хийж ажилласнаар үр дүнд хүрнэ гэдгийг судалгаа харуулж байна.

Ном зүй

- Алтангэрэл. (2020, 3). Мэдлэг бүтээх үйл явцыг сэтгэл судлалын зарим онолын үүднээс тайлбарлах нь. *Дээд боловсрол*, 1(1), 110.
- Батхуяг. (2006, 5). Оюутны бүтээлд хийсэн судалгааны зарим үр дүнгээс. *Оюуны хөтөч*, 45.
- Буянжаргал, А., Жаргалсайхан, Б. (2017, May 10). Оюутны бие даах ажлын нэгэн хувилбар. *МУБИС-ийн Лавай сэтгүүл*, 18, 47-48.

- Сохин, Ф.А. (2002). *Психолого-Педагогические основы развития речи дошкольников* (Vol. 1). (Д.И.Фельдштейн, Ed.) Воронеж, Россия, Москва: Издательство НПО "МОДЭК".
- Энхтүвшин. (2012). Оюутны бие даах ажилд хийсэн судалгааны зарим үр дүнгээс. *Оюуны хөтөч*, 298.
- Батхуяг. (2006, 5). Оюутны бүтээлд хийсэн судалгааны зарим үр дүнгээс. *Оюуны хөтөч*, 45.
- Энхээ, Д., Мянгаржав, Б., & Вергелес, Г. И. (2016, May 12). Оюутны бие даалтын ажлыг зохион байгуулахад технологийн карт ашиглах нь. *МУБИС-ийн Лавай сэтгүүл*, 14, 168-172.
- Алтангэрэл. (2020, 3). Мэдлэг бүтээх үйл явцыг сэтгэл судлалын зарим онолын үүднээс тайлбарлах нь. *Дээд боловсрол*, 1(1), 110.
- Ф.А.Талызина. (1998). *Педагогическая Психология* (Vol. 1). Москва: Издательство "Академия".
- Keane, E., Labhrainn, I. M. (2005). *Obtaining Student Feedback on*. Galway: Centre for Excellence in Learning & Teaching.
- Thanh, D. J. (2015). *Student Feedback Mechanisms* (Vol. 1). (D. Jussi, Ed.) University Krems (Austria), University of Tampere (Finland), and Osnabrück University of Applied Sciences (Germany), Austria, Finland, and Germany, Austria, Finland, and Germany: UNIVERSITY OF TAMPERE School of Management Higher Education Administration.
- Талызина. (1998). *Педагогическая Психология*. Москва.

Assistance Mechanism of the Students' Self-Study Assignment

Narantsetseg Tsogt

Khulunbuir University, Khulunbuir, China

Corresponding author: ts_narantsetseg@msue.edu.mn 

Received: 4/02/2020/

Revised: 9/14/2020

Accepted: 9/28/2020

Abstract

In recent years, a number of renovations have been made within the educational reform agenda. Curriculum reform is a part of this movement. Teacher's main role in the classroom is to assist students to acquire a positive learning approach, support them in finding their goals and objectives, assist them in applying appropriate tools and look for signs of trouble and fix them in a timely manner. This paper examines students' coursework performance on "Child Speech and Language Development" course which was subject to the curriculum reform. Within the objectives of "Child Speech and Language Development" course curriculum reform, the School of Preschool Education implemented a student assistance program from 2017 to 2019 to improve students' coursework performance. We evaluated the student assistance program run before 2016 and came into conclusion that it was not enough systematic and effective; therefore, we tried to carefully re-design the student assistance program. The redesigned program consists of four parts including general assistance, test assistance, detailed assistance and other assistance. And each part of the assistance program has 3 to 8 tracks. The redesigned program was experimented in the academic year of 2017 and 2019. In the course of the study we compared and evaluated coursework papers of 30 students from the academic year of 2017, 2018 and 2019. Student course works were evaluated in accordance to the 5 main rubric questions. The criteria cover the construction of conceptual framework, selection of tools, documentation of research, provision of clear and correct conclusion and, lastly, appropriate writing standards. The paper concludes that student coursework performance in the past 3 years significantly depended on the instructor's systematic and elaborate assistance.

Keywords

Lesson curriculum, child speech and language development, self independent work

